



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/154

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ийн "а", 29.1.6.-ийн "г", Захиргааны ерөнхий хуулийн 40.2.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны ээлжит IX дүгээр хуралдааны 04 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 05 дугаар хурлаар иргэдийн өргөдөл, байгууллагуудын гаргасан хүсэлтийг хэлэлцэн Мөрөн сумын хэсгийн ахлагч нарын зөвлөгөөнд 4,337,500 төгрөг, аймгийн Залуу багш нарын зөвлөгөөнд 1,050,000 төгрөгний дэмжлэг, эрүүл мэндийн байдлыг нь харгалзан үзэж Цагааннуур сумын иргэн Х.Батчулуунд 150,000 төгрөгийн тусламж дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх 5,537,500 (Таван сая таван зуун гучин долоон мянган) төгрөгийг аймгийн Засаг дарга данснаас гаргаж зарцуулахыг аймгийн Ерөнхий санхүүч (Ц.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л. ГАНБОЛД